

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АЙМАГ ДУНДЫН ОТРЫН БЭЛЧЭЭР
АШИГЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
Ч.ТАВИНЖИЛ ТАНАА

2021-02-25 № 07/477
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэс болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>77,869,610.00</u>	<u>125,536,501.00</u>
33	АВЛАГА	43,389,350.00	100,222,141.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	43,389,350.00	100,222,141.00
35	БАРАА МАТЕРИАЛ	34,480,260.00	25,314,360.00
354	Хангамжийн материал	34,480,260.00	25,314,360.00
35410	Бичиг хэргийн материал	8,189,780.00	8,149,780.00
35420	Аж ахуйн материал	1,691,000.00	1,474,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	6,837,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,840,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	20,759,480.00	8,853,580.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,071,022,322.54	2,769,469,946.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>3,071,022,322.54</u>	<u>2,769,469,946.13</u>
392	Биет хөрөнгө	2,062,831,970.94	1,760,479,594.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,947,446,765.27	1,947,446,765.27
39202	Хуримтлагдсан элэгдэл	(696,579,922.30)	(798,607,916.74)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	370,611,920.77	370,611,920.77
39204	Хуримтлагдсан элэгдэл	(238,753,588.17)	(267,580,255.17)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	426,048,057.00	435,958,057.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(276,937,919.71)	(350,822,676.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,497,274.96	32,497,274.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,239,382.41)	(20,599,135.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,301,019,528.00	1,301,019,528.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(784,280,762.47)	(889,443,967.63)
393	Биет бус хөрөнгө	1,008,190,351.60	1,008,990,351.60
39303	Бусад биет бус хөрөнгө	1,009,130,521.60	1,010,230,521.60
39304	Хуримтлагдсан элэгдэл	(940,170.00)	(1,240,170.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,148,891,932.54</u>	<u>2,895,006,447.13</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,148,891,932.54</u>	<u>2,895,006,447.13</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,148,891,932.54	2,895,006,447.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,532,738,464.28	2,532,738,464.28
51101	Өмч: - төрийн	1,526,048,112.68	1,526,048,112.68
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	1,006,690,351.60	1,006,690,351.60
512	Хуримтлагдсан үр дүн	506,839,770.79	252,954,285.38
51210	Өмнөх үеийн үр дүн	506,839,770.79	506,839,770.79
51220	Тайлант үеийн үр дүн	-	(253,885,485.41)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	109,313,697.47	109,313,697.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,148,891,932.54</u>	<u>2,895,006,447.13</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>583,384,168.61</u>	<u>853,973,227.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,842,668.61	7,417,727.00
120	Нийтлэг татварын бус орлого	41,842,668.61	7,417,727.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,842,668.61	7,417,727.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	41,837,668.61	7,417,727.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>541,541,500.00</u>	<u>846,555,500.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	376,061,500.00	516,209,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	376,061,500.00	516,209,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	165,480,000.00	330,346,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	101,000,000.00	316,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,480,000.00	14,246,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	100,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>830,370,626.07</u>	<u>1,107,858,712.41</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	830,370,626.07	1,107,858,712.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	815,757,180.37	1,106,298,092.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,570,900.00	239,376,443.39
210101	Үндсэн цалин	105,494,600.00	179,886,522.15
210102	Нэмэгдэл	28,732,700.00	50,144,921.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,343,600.00	9,345,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,946,400.00	29,525,226.11
210201	Тэтгэврийн даатгал	12,203,500.00	20,334,892.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,435,700.00	2,392,340.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,148,600.00	1,913,872.46
210204	Ажилгүйдлийн даатгал	287,200.00	141,510.84
210205	Эрүүл мэндийн даатгал	2,871,400.00	4,742,610.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,343,400.00	1,893,400.00
210301	Гэрэл, цахилгаан	450,000.00	-
210304	Байрны түрээс	1,893,400.00	1,893,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,817,340.34	82,959,546.00
210401	Бичиг хэрэг	1,431,490.00	16,153,100.00
210402	Тээвэр, шатахуун	16,969,950.00	57,380,096.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,458,650.34	3,470,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,957,250.00	5,955,550.00

2105	Нормативд зардал	4,377,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,377,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,837,300.00	37,389,802.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,410,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,000.00	-
210604	Урсгал засвар	6,414,300.00	37,389,802.00
2107	Томилолт, зочны зардал	17,579,464.00	5,632,180.00
210702	Дотоод албан томилолт	17,579,464.00	5,632,180.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,914,754.57	321,404,541.93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	196,975,830.57	314,520,107.93
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	4,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	877,824.00	360,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	630,600.00	1,197,137.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	84,000.00	82,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	400,000.00
210807	Газрын төлбөр	346,500.00	345,297.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	396,370,621.46	388,116,953.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,474,464.00	75,554,577.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,500,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл	349,396,157.46	312,562,376.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,613,445.70	1,560,619.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,137,706.00	1,045,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,087,712.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,049,994.00	1,045,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,475,739.70	515,119.57
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,475,739.70	515,119.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(246,986,457.46)	(253,885,485.41)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(246,986,457.46)	(253,885,485.41)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>585,483,350.00</u>	<u>889,944,850.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	5,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	585,478,350.00	889,944,850.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	376,061,500.00	516,209,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	376,061,500.00	516,209,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	209,416,850.00	373,735,550.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	144,936,850.00	359,389,350.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,480,000.00	14,246,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	100,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	550,567,950.00	880,034,850.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	550,567,950.00	880,034,850.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	492,565,154.30	777,752,089.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,570,900.00	181,500,600.00
210101	Үндсэн цалин	105,494,600.00	114,684,083.31
210102	Нэмэгдэл	28,732,700.00	57,472,916.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,343,600.00	9,343,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,946,400.00	24,502,500.00
210201	Тэтгэврийн даатгал	12,203,500.00	17,242,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,435,700.00	1,815,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,148,600.00	1,452,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	287,200.00	363,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,871,400.00	3,630,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,343,400.00	1,893,400.00
210301	Гэрэл, цахилгаан	450,000.00	-
210304	Байрны түрээс	1,893,400.00	1,893,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,681,630.34	19,581,950.00
210401	Бичиг хэрэг	1,451,790.00	2,428,900.00
210402	Тээвэр, шатахуун	14,877,390.00	13,154,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,458,650.34	3,470,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,893,800.00	527,750.00

2105	Нормативд зардал	10,767,000.00	521,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,767,000.00	521,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,764,250.00	57,112,502.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,793,800.00	114,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	569,800.00	-
210604	Урсгал засвар	7,400,650.00	56,998,202.00
2107	Томилолт, зочны зардал	17,142,584.00	6,170,080.00
210702	Дотоод албан томилолт	17,142,584.00	6,170,080.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	216,674,525.96	478,006,557.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	214,735,601.96	474,522,123.43
210803	Даатгалын үйлчилгээ	877,824.00	360,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	630,600.00	1,197,137.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	84,000.00	82,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,500,000.00
210807	Газрын төлбөр	346,500.00	345,297.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,674,464.00	8,463,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,174,464.00	8,463,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,500,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,002,795.70	102,282,760.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,137,706.00	1,545,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,087,712.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,049,994.00	1,545,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,865,089.70	100,737,260.57
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,865,089.70	100,737,260.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	34,915,400.00	9,910,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	34,915,400.00	9,910,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,915,400.00	9,910,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	34,915,400.00	9,910,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,915,400.00	9,910,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(34,915,400.00)	(9,910,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,532,738,464.28	109,313,697.47	753,826,228.25	3,395,878,390.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-246,986,457.46	-246,986,457.46
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,532,738,464.28	109,313,697.47	506,839,770.79	3,148,891,932.54
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-253,885,485.41	-253,885,485.41
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,532,738,464.28	109,313,697.47	252,954,285.38	2,895,006,447.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	516,209,300.00	515,794,180.43	415,119.57	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	516,209,300.00	515,794,180.43	415,119.57	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	514,663,800.00	514,248,680.43	415,119.57	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,500,600.00	181,500,600.00	-	100.0
210101	Үндсэн цалин	121,584,200.00	114,684,083.31	6,900,116.69	94.3
210102	Нэмэгдэл	50,572,800.00	57,472,916.69	(6,900,116.69)	113.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,343,600.00	9,343,600.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,502,500.00	24,502,500.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	17,242,500.00	17,242,500.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,815,000.00	1,815,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,452,000.00	1,452,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	363,000.00	363,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,630,000.00	3,630,000.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,893,400.00	1,893,400.00	-	100.0
210304	Байрны түрээс	1,893,400.00	1,893,400.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	13,047,000.00	12,760,750.00	286,250.00	97.8
210401	Бичиг хэрэг	1,628,900.00	1,628,900.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	7,133,300.00	7,133,300.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,470,800.00	3,470,800.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	814,000.00	527,750.00	286,250.00	64.8
2105	Нормативт зардал	521,000.00	521,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	521,000.00	521,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,048,700.00	62,042,502.00	6,198.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,048,100.00	5,044,300.00	3,800.00	99.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	600.00	-	600.00	-
210604	Урсгал засвар	57,000,000.00	56,998,202.00	1,798.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	6,170,500.00	6,170,080.00	420.00	100.0
210702	Дотоод албан томилолт	6,170,500.00	6,170,080.00	420.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	216,514,500.00	216,394,348.43	120,151.57	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	212,973,300.00	212,909,914.43	63,385.57	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	360,000.00	360,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,250,600.00	1,197,137.00	53,463.00	95.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	84,100.00	82,000.00	2,100.00	97.5

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	346,500.00	345,297.00	1,203.00	99.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,465,600.00	8,463,500.00	2,100.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,465,600.00	8,463,500.00	2,100.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,545,500.00	1,545,500.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,545,500.00	1,545,500.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,545,500.00	1,545,500.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	516,209,300.00	515,794,180.43	415,119.57	99.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	516,209,300.00	515,794,180.43	415,119.57	99.9
122005	Орон нутгийн төсвөөс	516,209,300.00	515,794,180.43	415,119.57	99.9
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	22	22	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	21	21	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12	-	100.0
620004	Гэрээт ажилтан	8	8	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		273,413,409.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		273,413,409.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		273,413,409.00
2104	Хангамж, бараа материалын зардал		6,821,200.00
210401	Бичиг хэрэг		800,000.00
210402	Тээвэр, шатахуун		6,021,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		266,592,209.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		266,592,209.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		373,735,550.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		373,735,550.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		359,389,350.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		14,246,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		100,000.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч Ч.Тавинжил танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн бодлого, балансын данстын талаар, мөнгөн хөрөнгө зарцуулалт, шуудан холбоо, шатахуун зарцуулалтын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Дундманхайдай Аудит” ХХК-ийн захирал Ж.Бямбажав, аудитор Н.Тэмүүжин нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газар, “Дундманхайдай Аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 22-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа нь “Аймаг дундын отрын бүсийн бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах замаар мал сүргийг байгалийн гэнэтийн болон давагдашгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, оторчид, малчдад, төрийн үйлчилгээг үзүүлэх” эрхэм зорилготой.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Отрын бүс нутгийн бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулахтай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох.
- Отрын бүс нутгийн бэлчээрийн төлөв байдалд тандалт, хяналт үнэлгээ хийх замаар түүнийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, шинээр отрын нөөц бүс нутаг бий болгох ажлыг зохион байгуулах.
- Отрын бүс нутгийн бэлчээрийн усан хангамжийг сайжруулна.
- Отрын бүс нутагт өвс тэжээлийн нөөц бий болгож, мал сүргийн байгалийн эрсдэлийг даван туулах чадамжийг нэмэгдүүлнэ.
- Оторчдын нийгмийн ая тухтай нөхцөлийг хангах зэрэг болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэл хоёр хувиар нэмэгдсэн.

- Төрийн үйлчилгээний албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр олгож эхэлсэн байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж буй хэдий ч төсөл хөтөлбөрийн талаарх бүртгэлийн бодлогыг сайжруулах шаардлагатай байна.

ХХААХҮЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд тус захиргааны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 481,357.9 мянган төгрөгөөс тооцон 9,627.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлсон.

Гүйцэтгэлийн шатанд дахин хянаж материаллаг байдлын түвшнийг тооцохдоо суурийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 2 хувиар тооцож 22,157.2 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 253,885.5 мянган төгрөгөөр буюу 9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага 56,832.8 мянган төгрөгөөр өсөж, бараа материал 9,165.9 мянган төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгө 301,552.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	43,389.3	100,222.1	56,832.7
Бараа материал	34,480.2	25,314.3	(9,165.9)
Үндсэн хөрөнгө	3,071,022.3	2,769,469.9	(301,552.3)

НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,148,891.9	2,895,006.4	(253,885.4)
Засгийн оруулсан капитал	2,532,738.4	2,532,738.4	-
Хуримтлагдсан үр дүн	506,839.7	252,954.2	(253,885.4)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	109,313.7	109,313.7	-
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,148,891.9</u>	<u>2,895,006.4</u>	<u>(253,885.4)</u>

Авлага дансны үлдэгдэл өссөн нь Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн 2020 оны санхүүжилтээс зарцуулагдаагүй үлдсэнээс шалтгаалсан. Авлага дансны үлдэгдэл 100,222.1 мянган төгрөг нь 2020 оны нэмэлт санхүүжилтээс зарцуулагдаагүй үлдсэн Сангийн яамны төрийн сангийн газраас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 2019 онд орлого авсан бараа материалын үлдэгдлээс 2020 онд зарцуулагдсанаас шалтгаалсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаар буурч, урсгал санхүүжилт болон нэмэлт санхүүжилтээр бэлтгэсэн 9,910.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Урсгал төсөвт тусгагдсан Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн санхүүжилтээр 3 ширхэг принтер, 2 ширхэг зөөврийн компьютер, 1 ширхэг телевизор бэлтгэн бүртгэлд тусгажээ.

2020 онд тус захиргаа нь урт болон богино хугацаат өр төлбөргүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 516,209.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 516,209.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг өөрчлөлтгүй баталсан байна. Төсвийн төсөл өмнөх оноос 140,147.8 мянган төгрөгөөр илүү байгаа нь орон нутгийн отрын бэлчээр ашиглалтыг сайжруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хамгаалалтыг сайжруулахад орон нутгийн иргэдийг татан оролцуулах шинжилгээ судалгаа хийж гүйцэтгэхэд шаардлагатай зардлыг тусгасан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 17 арга хэмжээнд зориулж улсын төсвөөс 516,209.3 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал зардал 515,794.2 мянган төгрөгийг зарцуулж 415.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 515,794.2 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс 286.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 120.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 373,735.5 мянган төгрөгийн санхүүжилтийг Швейцарын хөгжлийн агентлагийн “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төслийн төсөл, Мал Эмнэлгийн Ерөнхий Газар, тендерийн бичиг баримтын орлогоос санхүүжсэн. Үүний 359,389.3 мянган төгрөгийг гадаад төсөл хөтөлбөрөөс, 14,246.2 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчаас, 100.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр бараа үйлчилгээний зардал 273,413.4 мянган төгрөгийг зарцуулж, 100.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 144 мэдээллээс 138 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээлэл хугацаа хоцроосон, 5.0 сая төгрөгөөс дээших орлого, зарлагын 37 төрлийн 1,071.2 мянган төгрөгийн гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага өгөгдөөгүй байна. Аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 48,776.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 45,545.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 736.0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 2,495.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстад түүврийн сорилыг гүйцэтгэхэд тээвэр шатахуун, томилт, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал зэрэг нийт 45,544.5 мянган төгрөгийн анхан шатны баримтын дансны бичилтийн алдааг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 736.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тус захиргаа нь тайлант хугацаанд 2 иргэнтэй Хөлсөөр ажиллах гэрээ байгуулан, ажлын хөлсийг олгохдоо 736.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцоогүй нь: ХХОАТ-ын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шууд бус орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо эдгээр орлогын нийт дүнгээр тооцно”, 21 дүгээр зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба “Оршин байх”, “Үнэн зөв байх”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ суутган тооцож төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2,495.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглаж байгаа боловч “0” үлдэх өртөгтэй болсон 736,662.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй 75 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлсэн эсэх, Швейцарын хөгжлийн сангаас Ногоон алт-Малын эрүүл мэндийн төслөөс олгож байгаа гэрээт ажилчдын цалинд горим сорил хэрэгжүүлнэ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1.НБББББ-тэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

ХХААХҮЯмны салбарын харьяа байгууллагуудаас санал авч эрх бүхий байгууллагаар НБББББ-ийг боловсруулсан байна. Гэвч тухайн байгууллагын төсөл хөтөлбөрийн онцлог бүртгэл тусгагдаагүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" гэсэн заалтыг хэрэгжүүлэх, онцлог бүртгэлээ нарийвчлан судалж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусган, мөрдөж ажиллах;

1.4. Байгууллагаас өгсөн харуу тайлбар:

2019 онд ХХААХҮЯ-ны салбарын харьяа байгууллагуудаас санал авч эрх бүхий байгууллагаар НБББББ-ийг боловсруулан ХХААХҮС-ын тушаалаар баталгаажуулан мөрдөж байгаа ба манай байгууллагын НББ-ийн онцлог бүрэн тусгагдсан гэж үзэж байгаа. Судалж зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

4.2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Кассын тайлангийн бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт дугаарлагдаагүй, дараа тайлан тооцооны 728.5 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баримтын бүрдэл дутуу, 12 дугаар сарын тайланд өмнөх 6 сарын баримтаар гүйлгээ хийсэн зөрчил илэрлээ.

2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, мөнгөн хөрөнгийн тайлан гаргаагүй, ажил гүйлгээг бүртгэлд тусгаагүй байх;

2.3 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 -д."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг

заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага,” гэсэн заалтуудыг мөрдөх, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4.3.Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

2019 онд шуудан холбоо интернэтийн төлбөр 212.8 мянган төгрөгийг өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгалгүйгээр тайлант жилийн төсвөөс олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй

Тайлант хугацааны шатахуун зарцуулалтын тайланг шалгахад тус байгууллагын хөрөнгөд бүртгэлгүй, ажилтны хувийн автомашинд тушаал, шийдвэргүйгээр шатахуун олгож зарцуулсан, шатахууны зарлагын баримтад хүлээн авсан, олгосон хүний гарын үсэг зурж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 -д."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэнтэй ба үнэн зөв батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Үр дүнгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.1 -д."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтууд хэрэгжүүлж ажиллах;

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2019 оны 12-р сарын интернэт хэрэглээний төлбөр дараа сарын дундуур тооцоологдож хэдэн төгрөгийн төлбөр гарах нь мэдэгддэггүй тул өглөгөөр бүртгэх боломжгүй байгаа.

Захиргаа нь 9 газар орон нутгийг хариуцан ажиллаж байгаа ба отрын бүс нутгуудад нийт 4 фургон автомашинаар үүрэг гүйцэтгүүлдэг ба үлдсэн 5 орон нутагт албаны бүртгэлтэй тээврийн хэрэгсэл байхгүй учир мэргэжилтнүүдийн хувийн унаанд түлш, шатахуунаар хангаж ажил үүргийн гүйцэтгүүлж байна.

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.16	Аудитын нэр: Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/117/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	ХХААХҮЯ-ны салбарын НБББББ-т тус захиргааны төсөл хөтөлбөрийн онцлог бүртгэл тусгаагүй байна	0	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Ч.Тавинжил М.Энхсайхан
2	Кассын дэлгэрэнгүй тайлангаар 2020 оны 06 сарын 10-ний өдрийн баримтаар 728.5 мянган төгрөгийг 12 сард олгосон зөрчилтэй	728.5	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Ч.Тавинжил М.Энхсайхан
3	Шуудан холбоо интернэтийн төлбөр 212.8 мянган төгрөгийг өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгалгүйгээр тайлант жилийн төсвөөс олгосон	212.8	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Ч.Тавинжил М.Энхсайхан
4	Тайлант хугацааны шатахуун зарцуулалтаар ажилтны хувийн автомашинд тушаал, шийдвэргүйгээр шатахууны талон олгож зарцуулсан, шатахууны зарлагын баримтад хүлээн авсан, олгосон хүний гарын үсэг зурж баталгаажуулаагүй	1554.6	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Ч.Тавинжил М.Энхсайхан
5	Чилэнгийн агуулах тариан талбайн манаач, оффисын үйлчлэгч нарын ажлын хөлснөөс ХХОАТ 10 хувь суутган тооцоогүй	736.0	Акт тогтоов	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Ч.Тавинжил М.Энхсайхан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 06/A0150053

Улаанбаатар хот

САГ-2021/117/СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус захиргаа нь тайлант хугацаанд 2 иргэнтэй хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулан, ажил гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөхдөө ХХОАТ-ын 10 хувийг суутган тооцоогүй байна.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шууд бус орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо эдгээр орлогын нийт дүнгээр тооцно", 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Гэрээт 2 иргэний ажлын хөлснөөс суутган тооцоогүй 736,000.00 төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сангийн банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны дарга Ч.Тавинжил, Нягтлан бодогч М.Энхсайхан нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ"
ХХК АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ

